



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/817

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбооны 23 дугаар их хуралд манай аймгаас оролцох бүрэлдэхүүний шатахууны зардалд 571 200 төгрөг, Засаг даргын нэрэмжит шагналын фото цаас худалдаж авсан зардалд 300 000 төгрөг, Засаг дарга Улаанбаатар хотод ажилласан зардалд 424 000 төгрөг, Засаг даргын зөвлөлийн хурал зохион байгуулсан зардалд 408 900 төгрөг, Гавьяат багш цол хүртсэн Цаст-Алтай цогцолбор сургуулийн багш Б.Цэрмаад хүндэтгэл үзүүлэх зардалд 300 000 төгрөг, Буянт, Мянгад, Манхан сумдад Засаг дарга ажиллахад гарын бэлэгний зардалд 1 092 025 төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 3 096 125 төгрөг /Гурван сая ерөн зургаан мянга нэг зуун хорин таван/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн ангилагдаагүй зардлын нөөцөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ